



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Мандал сумын 3 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2025/187-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn Сүхбаатар сум 2025 он	ТАГ-ын дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn Аудитыг гүйцэтгэсэн: "Бэйкер Тилли Далайван аудит" ХХК Утас: 99396969 Цахим хаяг: urtaa6969@gmail.com
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын дүгнэлт	4-5
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	6-11
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	12-16
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	12
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	13
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	14-16
4. Аудитын тайлан	16-18
4.1 Ерөнхий зүйл	16
4.2 Материаллаг байдал	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
5. Аудитын илрүүлэлт	18-19
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	19

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БЕГ	Боловсролын ерөнхий газар
ТБОНӨХБАУХА	Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр ажил үйлчилгээ худалдах авах тухай
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

МАНДАЛ СУМЫН
3 ДУГААР ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ Г.ГЭРЭЛМАА ТАНАА

2025.02.25 № 177-11А-СА-143
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Мандал сумын 3 дугаар цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тус цэцэрлэг нь Боловсролын Ерөнхий газрын даргын 2024 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн А/355 дугаар тушаалаар сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнгээр 2 дугаар түвшинд үнэлэгдэж урамшуулалд 41,096.8 мянган төгрөгийн санхүүжилт авч зарцуулсан байна.

Аудитын гол асуудал

Дээд шатны төсвийн захирагчаас тус газрын тайлант оны төсвийн төлөвлөлт, хуваарилалтыг тухайн сарын гүйцэтгэлд үндэслэн тайлант онд нийт 7 удаа өөрчилж, зохицуулалт хийж байгаа буюу бодит гүйцэтгэлтэй уялдуулан өөрчилж

байгаа нь төсвийн төлөвлөлтийг тооцоо, судалгаанд үндэслэн бодитоор төлөвлөдөггүй болохыг харуулж байна.

Байгууллагын төсөв, санхүүжилтийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус “бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь тайлант оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 20 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 95.0 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ч.ӨНХТУЯА



2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/			
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	336,689,340.46	389,560,967.36
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	218,359,726.16	292,489,128.36
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	218,359,726.16	292,489,128.36
31210	Төгрөг	218,359,726.16	292,489,128.36
31211	Төрийн сангийн харилцах	218,359,726.16	292,489,128.36
35	БАРАА МАТЕРИАЛ	118,329,614.30	97,071,839.00
351	Түүхий эд материал	25,200.00	0.00
3511	Тусгай зориулалттай материал	25,200.00	0.00
35400	Хангамжийн материал	118,304,414.30	97,071,839.00
35460	Хүнсний материал	218,000.00	0.00
35470	Бусад хангамжийн материал	118,086,414.30	97,071,839.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,092,214,352.00	1,052,838,365.69
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,092,214,352.00	1,052,838,365.69
39200	Биет хөрөнгө	1,013,960,102.22	974,838,365.69
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,119,435,506.00	1,119,435,506.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(166,287,104.26)	(191,938,969.54)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	57,352,419.83	61,026,919.83
39206	Хуримтлагдсан элэгдэл	(41,026,219.53)	(50,456,231.31)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	30,537,642.18	35,458,642.18
39208	Хуримтлагдсан элэгдэл	(26,262,263.20)	(28,365,452.48)
39214	Бусад үндсэн хөрөнгө	68,467,482.61	68,467,482.61
39215	Хуримтлагдсан элэгдэл	(30,077,281.41)	(40,609,451.60)
39217	Ном	1,819,920.00	1,819,920.00
39300	Биет бус хөрөнгө	78,254,249.78	78,000,000.00
39301	Програм хангамж	1,496,000.00	1,496,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,241,750.22)	(1,496,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	78,000,000.00	78,000,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,428,903,692.46	1,442,399,333.05
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0.00	0.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,428,903,692.46	1,442,399,333.05
51	Засгийн газрын хувь оролцоо	1,428,903,692.46	1,442,399,333.05
51100	Засгийн газрын оруулсан капитал	442,957,637.20	442,957,637.20
51200	Хуримтлагдсан үр дүн	780,371,681.17	793,867,321.76
51210	Өмнөх үеийн үр дүн	780,371,681.17	780,371,681.17
51220	Тайлант үеийн үр дүн	0.00	13,495,640.59
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	205,574,374.09	205,574,374.09
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,428,903,692.46	1,442,399,333.05

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,730,826,338.07	2,248,799,154.48
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	9,524,770.00	11,460,762.60
120	Нийтлэг татварын бус орлого	9,524,770.00	11,460,762.60
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	0.00	5,000,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	5,000,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	3,543,900.00	6,460,762.60
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	5,980,870.00	0.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,721,301,568.07	2,237,338,391.88
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,597,729,800.00	2,134,357,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,597,729,800.00	2,134,357,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	0.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	123,571,768.07	102,980,891.88
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	123,571,768.07	102,980,891.88
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,546,293,663.51	2,235,303,513.89
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,546,293,663.51	2,235,303,513.89
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,512,380,863.51	2,194,206,713.89
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	912,033,210.00	1,454,650,668.00
210101	Үндсэн цалин	634,495,657.00	895,410,987.00
210102	Нэмэгдэл	247,183,913.00	498,692,390.00
210104	Урамшуулал	30,353,640.00	60,547,291.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	121,490,441.53	185,891,779.80
210201	Тэтгэврийн даатгал	84,497,688.11	126,736,468.39
210202	Тэтгэмжийн даатгал	9,813,269.84	15,537,428.59
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,362,216.12	7,713,629.31
210204	Ажилгүйдлийн даатгал	1,788,605.63	7,127,943.81
210205	Эрүүл мэндийн даатгал	18,028,661.83	28,776,309.70
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	100,863,768.07	99,510,891.88
210301	Гэрэл, цахилгаан	18,607,223.99	18,214,126.68
210302	Түлш, халаалт	67,063,377.08	61,653,324.20
210303	Цэвэр, бохир ус	15,193,167.00	19,643,441.00
2104	Хангамж, бараа материалын зардал	0.00	49,496,275.30
210408	Бараа материал акталсны зардал	0.00	49,496,275.30
2105	Нормативт зардал	242,932,550.00	284,486,400.00
210502	Хоол, хүнс	242,932,550.00	284,486,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	27,978,700.00	3,470,000.00
210604	Урсгал засвар	27,978,700.00	3,470,000.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,429,100.00	6,712,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,429,100.00	6,712,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	103,653,093.91	109,987,898.91
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	38,386,282.00	35,520,780.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	11,141,650.00	20,034,870.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	54,125,161.91	54,432,248.91
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	33,912,800.00	41,096,800.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	33,912,800.00	41,096,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	33,912,800.00	41,096,800.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	184,532,674.56	13,495,640.59
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	184,532,674.56	13,495,640.59

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

		/төгрөгөөр/	
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,721,301,568.07	2,242,338,391.88
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	0.00	5,000,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	0.00	5,000,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	0.00	5,000,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	5,000,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,721,301,568.07	2,237,338,391.88
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,597,729,800.00	2,134,357,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,597,729,800.00	2,134,357,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	0.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	123,571,768.07	102,980,891.88
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	123,571,768.07	102,980,891.88
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,511,650,951.60	2,159,613,489.68
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,511,650,951.60	2,159,613,489.68
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,477,738,151.60	2,118,516,689.68
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	912,033,210.00	1,454,650,668.00
210101	Үндсэн цалин	634,495,657.00	895,410,987.00
210102	Нэмэгдэл	247,183,913.00	498,692,390.00
210104	Урамшуулал	30,353,640.00	60,547,291.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	121,490,441.53	185,891,779.80
210201	Тэтгэврийн даатгал	84,497,688.11	126,736,468.39
210202	Тэтгэмжийн даатгал	9,813,269.84	15,537,428.59

210203	ҮОМШӨ-ний даатгал	7,362,216.12	7,713,629.31
210204	Ажилгүйдлийн даатгал	1,788,605.63	7,127,943.81
210205	Эрүүл мэндийн даатгал	18,028,661.83	28,776,309.70
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	100,863,768.07	99,510,891.88
210301	Гэрэл, цахилгаан	18,607,223.99	18,214,126.68
210302	Түлш, халаалт	67,063,377.08	61,653,324.20
210303	Цэвэр, бохир ус	15,193,167.00	19,643,441.00
2105	Нормативт зардал	242,523,850.00	284,268,400.00
210502	Хоол, хүнс	242,523,850.00	284,268,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	22,708,000.00	3,470,000.00
210604	Урсгал засвар	22,708,000.00	3,470,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,429,100.00	7,090,800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	378,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,429,100.00	6,712,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	74,689,782.00	83,634,150.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	64,255,082.00	63,599,280.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,434,700.00	20,034,870.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	33,912,800.00	41,096,800.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	33,912,800.00	41,096,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	33,912,800.00	41,096,800.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	209,650,616.47	82,724,902.20
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	0.00	0.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	0.00	8,595,500.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.00	8,595,500.00
2200	Дотоод эх үүсвэрээр	0.00	8,595,500.00
222001	Тоног төхөөрөмж	0.00	3,674,500.00
223001	Бусад хөрөнгө	0.00	4,921,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	0.00	(8,595,500.00)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.00	0.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	209,650,616.47	74,129,402.20
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		218,359,726.16
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		292,489,128.36

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	442,957,637.20	205,574,374.09	780,371,681.17	1,428,903,692.46
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	13,495,640.59	13,495,640.59
20	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	442,957,637.20	205,574,374.09	793,867,321.76	1,442,399,333.05

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,470,744,500.00	2,168,208,989.68	302,535,510.32	87.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,470,744,500.00	2,168,208,989.68	302,535,510.32	87.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,429,647,700.00	2,127,112,189.68	302,535,510.32	87.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,720,753,200.00	1,454,650,668.00	266,102,532.00	84.5
210101	Үндсэн цалин	1,144,645,200.00	895,410,987.00	249,234,213.00	78.2
210102	Нэмэгдэл	534,494,100.00	498,692,390.00	35,801,710.00	93.3
210104	Урамшуулал	41,613,900.00	60,547,291.00	(18,933,391.00)	14.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	198,778,800.00	185,891,779.80	12,887,020.20	93.5
210201	Тэтгэврийн даатгал	135,173,700.00	126,736,468.39	8,437,231.61	93.8
210202	Тэтгэмжийн даатгал	15,898,200.00	15,537,428.59	360,771.41	97.7
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,951,000.00	7,713,629.31	237,370.69	97.0
210204	Ажилгүйдлийн даатгал	7,951,000.00	7,127,943.81	823,056.19	89.6
210205	Эрүүл мэндийн даатгал	31,804,900.00	28,776,309.70	3,028,590.30	90.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	109,557,400.00	99,510,891.88	10,046,508.12	90.8
210301	Гэрэл, цахилгаан	20,973,700.00	18,214,126.68	2,759,573.32	86.8
210302	Түлш, халаалт	68,465,800.00	61,653,324.20	6,812,475.80	90.0
210303	Цэвэр, бохир ус	20,117,900.00	19,643,441.00	474,459.00	97.6
2105	Нормативт зардал	290,133,800.00	284,268,400.00	5,865,400.00	98.0
210502	Хоол, хүнс	290,133,800.00	284,268,400.00	5,865,400.00	98.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,470,000.00	3,470,000.00	0.00	100.0
210604	Урсгал засвар	3,470,000.00	3,470,000.00	0.00	100.0

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний	11,915,800.00	11,712,800.00	203,000.00	98.3
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний	5,000,000.00	5,000,000.00	0.00	100.0
210806	Мэдээлэл, технологийн	6,915,800.00	6,712,800.00	203,000.00	97.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	95,038,700.00	87,607,650.00	7,431,050.00	92.2
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	75,003,800.00	67,572,780.00	7,431,020.00	90.1
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	20,034,900.00	20,034,870.00	30.00	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	41,096,800.00	41,096,800.00	0.00	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	41,096,800.00	41,096,800.00	0.00	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал	41,096,800.00	41,096,800.00	0.00	100.0
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,252,384,900.00	2,242,338,391.88	10,046,508.12	99.6
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,247,384,900.00	2,237,338,391.88	10,046,508.12	99.6
131001	Улсын төсвөөс санхүүжих	2,134,357,500.00	2,134,357,500.00	0.00	100.0
	Орон нутгийн төсөв	113,027,400.00	102,980,891.88	10,046,508.12	91.1
120004	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	5,000,000.00	5,000,000.00	0.00	100.0
120004 2	Туслах үйл ажиллагааны орлогоос	5,000,000.00	5,000,000.00	0.00	100.0
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		218,359,726.16	0.00	
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		292,489,128.36	0.00	

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Мандал сумын 3 дугаар цэцэрлэг нь “Бага насны хүүхдийн эрүүл, аюулгүй, ээлтэй орчинд сурч, хөгжих нөхцөлийг бүрдүүлэх, хүүхэдтэй зүй бус харилцах, хүүхдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх, хүүхдийн эрхийг дээдлэн ажиллах” гэсэн эрхэм зорилгыг дэвшүүлсэн байна

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хүүхэд бүрийн сургалтын байгууллагын орчинд амар тайван суралцах, аливаа дарамтаас ангид тэгш хүртээмжтэй эрүүл аюулгүй орчныг бүрдүүлэхэд талуудын идэвхтэй хамтын ажиллагаа түншлэлийг нэмэгдүүлэх,
- Хүүхэд өөрийгөө зөв илэрхийлэх, бусдыг хүндэтгэх, харилцааны хэлбэрээс хүчирхийллийг ялгах, мэдээлэх чадвартай болгох, түүх үндэсний ёс заншлын талаар мэдлэг чадвар хандлагыг төлөвшүүлэх,
- Сургуулийн өмнөх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд олгох ганцаарчилсан сургалтын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэн ажиллах,
- Хүүхдийн хөгжлийн үр дүнгийн нэгтгэл судалгаа гарган ажиллах,

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- *Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой;*
- *Засгийн газрын 2024 оны 01 сарын 25-ны өдрийн 39 дүгээр тогтоолоор “Хувьсах зардал болон гүйцэтгэл, үр дүнд суурилан санхүүжүүлэх журам”;*
- *Засгийн газрын 2024 оны 01 сарын 17-ны өдрийн 25 дугаар тогтоолоор “Боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааны болон багшийн ажлын гүйцэтгэл, чанар, үнэлгээний үр дүнд үндэслэн олгох нэмэлт урамшууллыг санхүүжүүлэх журам”;*
- *Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ний өдрийн 128 дугаар тогтоолоор Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон;*
- *Засгийн газрын 2024 оны 05 сарын 29 өдрийн 237 дугаар тогтоолоор цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлын хэмжээг шинэчлэн тогтоосон;*
- *Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 28-ний өдрийн 84 дүгээр тогтоолоор хөдөө орон нутгийн нэмэгдэл шинэчлэгдсэн гэх мэт.*

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналт, үйл ажиллагааны зохион байгуулалтын хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тайлант онд тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд Боловсролын ерөнхий газрын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас хяналт, шалгалт хийгдээгүй боловч сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан дотоод хяналт, шалгалтыг хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Мандал сумын 3 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Мандал сумын 3 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 13,465.6 мянган төгрөгөөр буюу 0.9 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	218,359.7	292,489.1	74,129.4
Авлага			
Бараа материал	118,329.6	97,071.8	(21,257.8)
Үндсэн хөрөнгө	1,092,214.4	1,052,838.4	(39,376.0)
Нийт хөрөнгө	1,428,903.7	1,442,399.3	13,495.6
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,428,903.7	1,442,399.3	13,495.6
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,428,903.7	1,442,399.3	13,495.6

Дээрх хүснэгтээс харахад, нөлөө бүхий өөрчлөлт гарсан дараах данснууд байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 292,489.1 мянган төгрөг болж 74,129.4 мянган төгрөгөөр өссөн нь зардлын хэмнэлттэй холбоотой бөгөөд төрийн сангийн харилцах дансанд үлдэгдлээр тайлагнагдсанаас,
- Бараа материал дансны үлдэгдэл 97,071.8 мянган төгрөг болж 21,257.8 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 385,370.9 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 357,132.4 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулан, цэцэрлэгийн эрхлэгчийн 2024 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн А/07 дугаар тушаалаар ашиглах боломжгүй 49,496.3 мянган төгрөгийн бараа материал акталснаас,
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл *ланхны өртгөөр* 1,365,704.4 мянган төгрөг болж 8,595.5 мянган төгрөгөөр өссөн төсвийн хөрөнгөөр 8,595.5 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, орон нутгийн өмчийн газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 452 дугаар албан бичгээр ашиглалтын хугацаа нь дууссан дахин ашиглах боломжтой 6,460.7 мянган төгрөгийн тавилга эд хогшил, тоног төхөөрөмжийн ашиглалтын хугацааг сунгасан, 54,432.2 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцсоноос тус тус шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд улсын төсвөөс 1,405,957.8 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 129,002.0 мянган төгрөг нийт 1,534,959.8 мянган төгрөгийн санхүүжилт авч, зарцуулахаар дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн төсвийн төслийн саналыг цалин, НДШ-ийн зардлыг 115,579.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, хүүхдийн хоолны зардлыг 257,611.5 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 8,272.0 мянган төгрөгөөр нийт 265,883.5 мянган төгрөгөөр бууруулж нийт 1,384,655.3 мянган төгрөгөөр баталсан байна.

Тайлант онд 7 удаа төсвийн зохицуулалт хийгдэж цалин, НДШ-ийн зардлыг 921,249.9 мянган төгрөгөөр, тогтмол зардлыг 15,974.7 мянган төгрөгөөр, хүүхдийн хоолны зардлыг 32,522.3 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 66,087.0 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрийг 9,158.5 мянган төгрөгөөр, тэтгэмж урамшууллын зардлыг 41,096.8 мянган төгрөгөөр нийт 1,086,089.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн улсын төсвөөс 2,134,357.4 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 113,027.4 мянган төгрөг, дээд шатны төсвийн захирагчаас 5,000.0 мянган төгрөг, урьд оны үлдэгдлээс 218,359.7 мянган төгрөг зарцуулахаар төсвийг нийт **2,470,744.5** мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөр 9 арга хэмжээг санхүүжүүлэхээр төлөвлөсний дагуу 2,470,744.5 мянган төгрөгийн орлого бүрдүүлснээс урсгал үйл ажиллагаанд 2,168,209.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,168,209.0 мянган төгрөг буюу 87.8 хувьтай байгаа нь хүүхдийн хоолны зардлыг 5,865.4 мянган төгрөгөөр, үйл ажиллагааны зардлыг 296,670.1 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

<i>/мянган төгрөгөөр/</i>							
д/д	Хөтөлбөр	д/д	Арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү	Биелэлт
1	71802- Сургуулийн өмнөх боловсрол	1	81605- Эрүүл мэндийг дэмжих	4,655.8	4,065.0	590.8	87.3
		2	81807- Цэцэрлэгийн хүүхдийн хоол	290,133.9	284,268.4	5,865.5	98.0
		3	80233-Хүүхэд хамгаалал	3,046.2	3,024.6	21.6	99.3
		4	81816- Зөв монгол хүүхэд	9,081.6	9,075.5	6.1	99.9
		5	81823- Боловсролын багшийн сургалт	4,711.5	4,002.1	709.4	84.9
		6	81834- Боловсролын стандарт сургалт	1,937,462.6	1,652,954.8	284,507.8	85.3
		7	81835- Сургалтын хэвийн үйл ажиллагаа	103,625.5	102,837.7	787.8	99.2
		8	80111-Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	113,027.4	102,980.9	10,046.5	91.1
		9	83603-Нэмэлт санхүүжилт	5,000.0	5,000.0	-	100.0
		Нийт		2,470,744.5	2,168,209.0	302,535.5	87.8

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Сангийн яамны 2022 оны 02 дугаар сарын 28-ны “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичгээр байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансыг хааж, нэмэлт санхүүжилттэй холбоотой гүйлгээг урсгал дансаар дамжуулан гүйцэтгэж, тайланг төсвийн гүйцэтгэлийн тайланд нэгтгэсэн байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант худалдан авах ажиллагааны урилгыг ТБОНӨХБАҮХАТ хуульд заасны дагуу tender.gov.mn-д цахим сайтад байршуулан хоол хүнсний 202,626.6 мянган төгрөг бараа ажил үйлчилгээг гүйцэтгэх бэлтгэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах нээлттэй тендер шалгаруулалтыг 2 удаа зарласан боловч гүйцэтгэгч ирээгүй учраас хоол хүнснийг “Цолмон маргад трейд” ХХК, “Хараа баян сувд” ХХК, “Шанзан ташуур” ХХК, “Мөнх хараа бадрах” ХХК, “Есөн гурвалжин” ХХК-иудтай шууд гэрээ байгуулан, худалдан авалтыг хийж гүйцэтгэсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Мандал сумын 3 дугаар цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу аудитор Б.Ундаръяа гүйцэтгэж, хяналтыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Мандал сумын 3 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Бэйкер Тилли Далайван аудит” ХХК-ийн Дархан салбарт 2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 03 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,546,293.7 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 15,462.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Мандал сумын 3 дугаар цэцэрлэг нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Үйл ажиллагаатай холбоотой сурталчилгаа, баяр ёслолын арга хэмжээг зохион байгуулаагүй, төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдаж аваагүй,
- Шаардлагагүй бараа материалыг их хэмжээгээр авч нөөцлөөгүй,
- Хэвлэл захиалгын төлбөр гаргалгүй ажилласан зэрэг төсвийн шууд захирагчтай хамааралтай заалтуудыг мөрдөж, батлагдсан төсвийн хүрээнд ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн системийн мэдээлбэл зохих 20 төрлийн 171 мэдээллээс 171 мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд :

Тайлант онд бусад хууль, тогтоомжийн хэрэгжилтэд хамаарах алдаа, зөрчил илрээгүй.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын даргын 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 173 дугаар албан бичгээр “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2024 оны 2 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар шалгуур үзүүлэлтийг харгалзаж дүгнэлгүйгээр 660.0 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдлийг илүү олгосон зөрчилд төлбөрийн акт тогтоосон байна.

Өмнөх оны аудитаар өгөгдсөн актын биелэлтийг нотлох баримттай тулган баталгаажуулахад 100.0 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	660.0	1	660.0	100.0
Нийт дүн	1	660.0	1	660.0	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой алдаа илрээгүй байна.

Аудитаар **5,254.0** мянган төгрөгийн зөрчил илэрч нөхөн төлбөрийн акт тогтоов.

5.1 Төлбөрийн акт

1.Тайлант онд өндөр насны тэтгэврээ тогтоолгон, төрийн албанаас бүрмөсөн чөлөөлөгдөж, гэрээгээр ажиллаж буй нярав Т.Даваадолгорт 705.8 мянган төгрөгийн төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг олгосон байна. Энэ нь Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам”-ын 2 дахь “Төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг тухайн төрийн албан хаагчийн төрийн байгууллагад ажилласан хугацааг харгалзан түүний албан тушаалын сарын үндсэн цалингаас ... бодож олгоно” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон цалинг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

2. Ур чадварыг шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлээгүй, аймгийн түвшинд амжилт гаргасныг нотлох баримтгүй 18 багшид 4,548.2 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдэл илүү олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, Боловсрол шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2021 оны 02 сарын 01-ний өдрийн А/35, А/102 дугаар хамтарсан “Шалгуур үзүүлэлт шинэчлэн батлах тухай” тушаалын 1 дүгээр хавсралтын 10 дахь “Энэхүү баримт бичгийн 4,5-д заасан

шалгуур үзүүлэлтийн дагуу хийсэн үнэлгээнд 60.0 ба түүнээс дээш хувь үнэлэгдсэн багш, ажилтны ажлын үр дүн, манлайлал, мэргэжлийн хөгжлийн ахиц дэвшил, амжилтын түвшнийг харгалзан нэмэгдлийг дараах хувиар тогтооно. **“цэцэрлэг, сургуулийн түвшинд амжилт гаргасан 10 хувь”** гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон үр чадварын нэмэгдлийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Запруулсан		Запруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Цалин илүү тооцож олгосон.	2	5,254.0	2	5,254.0								
Дүн	2	5,254.0	2	5,254.0								

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж					
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн				
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил												
Нийт												

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.